

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ӨМЧИЙН ХЯНАЛТ, АШИГЛАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ИЛТГЭХ ХУУДАС

2024 оны 07 дугаар сарын 16

Улаанбаатар хот

Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн
биелэлтийн хяналт- шинжилгээ

Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн биелэлтийг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсээс 2024 оны 07 дугаар сарын 09-ны өдөр хүлээн авч Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2 заасан аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэлээ. Дүрмээр хүлээсэн чиг үүргийн биелэлтийг байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр авч, тайлант хугацаагаар буюу 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тооцсон болно.

1.Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хуваарилалт

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/75 дугаар захирамжаар Нийслэлийн өмчийн харилцааны газрын дүрмийг шинэчлэн баталж, дүрмийн Дөрөвдүгээр хэсэгт дүрмээр хүлээсэн 16 чиг үүргийг баталсан байна. Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс 4, Өмчийн менежментийн хэлтэс 10, Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэс 9, Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс 3 чиг үүргийг хэрэгжүүлэн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан байна. Үүнд:

№	Үндсэн чиг үүрэг	Хэрэгжүүлэх хэлтэс
1.	нийслэлийн өмчөөс төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх;	ЗТСХ, ӨМХ ӨБМХ
2.	нийслэлийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалтад хяналт тавьж, үр ашгийг дээшлүүлэх, үргүй зардлыг багасгах;	ӨМХ
3.	нийслэлийн өмчийн барилга байгууламжид өргөтгөл шинэчлэл, их засвар, техник, технологийн өөрчлөлттэй холбогдсон хөрөнгө оруулалт хийх;	ӨМХ ӨБМХ
4.	Нийслэлийн өмчит төсөвт байгууллагын эд хөрөнгийн эзэмшил, захиран зарцуулахтай холбоотой харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, шинээр бий болсон эд хөрөнгийг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх	ӨБМХ
5.	Нийслэлийн өмчит төсөвт байгууллагуудын эд хөрөнгийн эзэмшил, захиран зарцуулалттай холбоотой харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, шинээр бий болсон эд хөрөнгийг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх;	ӨМХ ӨБМХ
6.	нийслэлийн өмчийн оролцоотой болон нийслэлийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүү, өмч хөрөнгийн эзэмшилт, ашиглалтад хяналт тавих, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, зөрчил, дутагдлыг арилгахыг шаардах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;	ӨХАДАХ
7.	нийслэлийн өмчид хийх хөрөнгө оруулалтын ажилд холбогдох шийдвэрийг үндэслэн захиалагчийн хяналт тавих;	ӨХАДАХ
8.	нийслэлийн өмчит байгууллагууд өөрийн эзэмшлийн эд хөрөнгө, газрыг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих;	ӨХАДАХ, ӨМХ ӨБМХ

9.	нийслэлийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөтлөх, эд хөрөнгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах;	ӨМХ ӨБМХ
10.	нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн бүртгэл, хөдөлгөөний талаар шийдвэр гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээллийн сан бүрдүүлэх;	ӨМХ ӨБМХ
11.	Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр нийслэлийн өмчид шилжин ирж байгаа хөрөнгийг хүлээн авч бүртгэх, эзэмшигчид нь хүлээлгэн өгөх, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавих асуудлаар санал боловсруулах, хэрэгжилтийг хангах	ӨМХ ӨБМХ
12.	нийслэлийн өмчид хувийн хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалтыг хянах, баталгаажуулах ажлыг зохион байгуулах, хувийн хөрөнгө оруулалтаар бий болсон, нийслэлд үнэ төлбөргүй шилжүүлэн өгч байгаа нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэн авч, ашиглалт хариуцсан байгууллагад хүлээлгэн өгөх асуудлаар санал боловсруулах, хэрэгжилтийг хангах	ӨМХ ӨБМХ
13.	нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан гэрээнд заасан үүргээ хангалтгүй биелүүлснээс нийслэлийн өмчид хохирол учруулсан, үрэгдүүлсэн, шамшигдуулсан зэрэг өмч хөрөнгийн холбогдолтой маргаанд нэхэмжлэгчээр оролцох	ЗТСХ
14.	Нийслэлийн өмчтэй холбогдон гарсан зөрчил, маргааныг зохицуулах, шийдвэрлэх, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	ЗТСХ
15.	Нийслэлийн өмчтэй холбоотой шүүхийн маргаанд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргыг төлөөлж оролцох	ЗТСХ
16.	Дүүргийн өмчийг удирдах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах	ӨМХ

2. Хэрэгжилтийн талаар

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2, 6.2.3 заасан аргачлалын дагуу дүрмээр хүлээсэн чин үүрэг тус бүрийн биелэлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд:

1. Орлогын ангилал бүрээр тайлагнаагүй, үнэлгээ 2.2.1 заалтын аргачлалаар 2024 оны хүрсэн түвшин 1,602.0 сая төгрөг, зорилтот түвшин 2,942.0 сая төгрөг, 2023 оны суурь түвшин 638.6 сая төгрөг буюу 90%, 6.2.2.1 заалтын хэрэгжилтийн хувь 90%, 6.2.3 зааснаар дундаж үнэлгээ 66%,.
2. НИТХ-ын 2024.07.24-ний өдрийн 97 дугаар тогтоолоор ОНӨААТҮГ-ын 2023 оны тайлангийн цэвэр ашгаас нийслэлийн төсөвт 1.3 тэрбум төгрөгийн ногдол ашиг төвлөрүүлэхээр баталсан, үнэлгээ 100%,
3. Буруу буюу ҮХХХК-ийн шийдвэртэй холбоотой биелэлт оруулсан. Тайлант хугацаанд нийслэлийн барилга, байгууламжид хийсэн өргөтгөл, шинэчлэл, их засвар г.м мэдээллийн шаардлагатай судалгаа, тооцоо хийсэн эсэх, чиг үүргийг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулсан нь тодорхойгүй, тайлагнаагүй, үнэлгээ 0%,
4. Нийслэлийн өмчит төсөвт байгууллагуудын удирдлагатай Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулан, шинээр бий болсон эд хөрөнгийг бүртгэх ажлыг зохин байгуулж, мэдээллийн сан бүрдүүлэн ажилласан 100%;
5. Орон нутгийн өмчийн оролцоотой хариуцлагатай компанийн засаглалыг сайжруулах, нийслэлийн өмчит хуулийн этгээдийн статусын хэлбэрийг өөрчлөх, татан буулгах ажлууд хийгдсэн, 100%
6. Хяналт шалгалтын төлөвлөгөө баталж, нийслэлийн өмчийн оролцоотой болон нийслэлийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүү, өмч хөрөнгийн эзэмшилт, ашиглалтад хяналт тавих, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, зөрчил, дутагдлыг арилгахыг мэдэгдсэн, 100%

7. Нийслэлийн Засаг даргын 2023-2024 оны эрх шилжүүлсэн захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт бүхий нийт 120.3 сая төгрөгийн өртөг бүхий 3 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт тавин санхүүжилтийг олгосон, 100%
8. Нийслэлийн өмчит байгууллагууд өөрийн эзэмшлийн эд хөрөнгө, газрыг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих биелэлт оруулаагүй, 0%
9. Нийслэлийн өмчит 877 хуулийн этгээд, 45 сангийн 2023 оны санхүүгийн тайлангийн хөрөнгийн мэдээллийг мэдээллийн санд баталгаажуулан, 2.3 их наяд төгрөгийн хөрөнгөөр нэмэгдүүлэн нийслэлийн өмчийн хөрөнгийн дүн 7.6 их наяд төгрөг болсон. Үнэлгээ 100%
10. ҮХХХК-ийн 3 удаагийн хурлаар давхардсан тоогоор 100 байгууллагын 16,786.0 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн, үнэлгээ 100%,
11. Улс, нийслэл, бусад хөрөнгөөр бий болсон нийт 82 төсөл арга хэмжээний хөрөнгийг эх үүсвэрээр нь ангилан судалгааг гаргасан, 100%
12. Хувийн хөрөнгө оруулалтаар бий болсон инжерийн шугам сүлжээг ОСНААУГ ОНӨААТҮГ-ын баланст бүртгүүлэн, ашиглалтыг хариуцуулсан, 100%
- 13-15. Байгууллагыг төлөөлж 3, НЗД-ыг төлөөлж 2, НИТХ-ыг төлөөлж 1, нийт 6 шүүхийн маргаанд итгэмжлэгчээр оролцосон, 100%
17. Мэдээ оруулаагүй, 0%

3. Дүгнэлт

Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн биелэлт бүрд хянал-шинжилгээ, үнэлгээ хийн 10 -100%, 1-66% (1 дэх), 3-0% (3,8,16 дахь) нийт 16 чиг үүргийн биелэлтийн дундаж **76.1%** үнэлэгдлээ.

4.Цаашид авах арга хэмжээний санал

- Дүрмээр хүлээсэн чиг үүргээ хугацаанд нь гүйцэтгэж, тайлагнах;
- Албан хаагчид удирдлагын чиглэлийг хүлээхгүйгээр чиг үүргийн асуудлаа хууль, дүрмийн дагуу хариуцаж, идэвх санаачилгатай ажиллах;
- Нийслэлийн удирдлагын өгсөн үүрэг, даалгаврыг чиг үүргийн хүрээнд хугацаанд нь биелүүлж, тухай бүр танилцуулах;
- Байгууллага бүр чиг үүргийнхээ хүрээнд иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, өргөдөл, гомдолд тавьсан асуудлыг судалж, нэг бүрд үндэслэлтэй хариу өгөх, эцэслэн шийдвэрлүүлэх;

ХЯНАСАН:

ӨХАДАХ-ЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Г.ТЭМҮҮЖИН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ӨХАДАХ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ж.СУВДАНЗАЯА